



## УВС АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

УАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан.

*УИХ-ын болон аймаг ИТХ-ын сонгуулийн зардлыг хууль, журмын дагуу зарцуулсан байна.*

***Монгол Улсын Их Хурлын болон аймгийн Иргэдийн  
Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн зардлын гүйцэтгэл***

## АГУУЛГА

|                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |  |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|
| <p><b><u>Тайлан бэлтгэсэн:</u></b></p> <p><b>Дарга, тэргүүлэх аудитор</b><br/>Б.Авирмэд</p> <p><b>Аудитын менежер</b><br/>Ж.Энхжаргал</p> <p><b>Аудитор</b><br/>Ч.Дуламсүрэн</p> <p>2016 оны 7 дугаар сар</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70453317, 7045-3721, 7045-4721, 70453799 дугаарын утсаар харилцана уу.</p> <p><b>Хаяг:</b><br/>Увс аймгийн Аудитын газар<br/>Улаангом сум 3 баг аймгийн<br/>Засаг даргын тамгын газрын<br/>байр</p> | <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</p> <p><b>Бүлэг 1. УИХ-ын болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн зардлыг хууль, журмын дагуу зарцуулсан байна.</b></p> <p>Дүгнэлт</p> <p><b>Бүлэг2. Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн байна.</b></p> <p>Дүгнэлт<br/>Зөвлөмж</p> <p><b>Холбогдох байгууллагын санал</b></p> <p><b>Аудитын газраас өгөх тайлбар</b></p> |  |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|

**Товчилсон үгийн тайлал:**

ҮАГ- Үндэсний аудитын газар

УИХ-Улсын их хурал

ИТХ- Иргэдийн төлөөлөлгчдийн хурал

## **АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ**

### **Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх**

Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, аймгийн Аудитын газрын 2016 оны ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

### **Аудитын зорилт**

Улсын Их Хурлын болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ.Үүнд:

- УИХ-ын болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулах хөрөнгийг холбогдох хууль журмын дагуу зарцуулсан эсэх
- Хөрөнгийн зарцуулалтад тавьж буй хяналт үр дүнтэй эсэх

### **Хамарсан хүрээ**

Аудитаар сумын сонгуулийн хороод, Улсын бүртгэл, статистикийн газар, Цагдаагийн газрыг хамрууллаа.

### **Арга зүй**

Аудитыг гүйцэтгэхэд ТХШС, Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, гүйцэтгэлийн болон санхүүгийн аудитын арга зүйг ашиглан улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтын талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, тайлан, судалгаа, баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийн аудитын судалгаа, хөтөлбөр, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт зөвлөмж боловсрууллаа.

Энэхүү гүйцэтгэлийн аудитыг явуулахад Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журмыг баримталж ажиллав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүгнэлт, зөвлөмжид дэмжлэг болохуйц нотлох зүйлс, холбогдох бусад материалыг ажлын баримтад хавсаргав.

### **Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлтүүд:**

Аудитад дараах хууль эрх зүйн актыг шалгуур болгон ашиглав.

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Сонгуулийн тухай хууль
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
- Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль
- Дээрх хуулиудтай нийцүүлэн тогтоол, журам

## **БҮЛЭГ 1. УИХ-ын болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн зардлыг хууль, журмын дагуу зарцуулсан байна.**

**1.1.** Увс аймагт УИХ-ын 2016 оны сонгуулийн 3 мандат, аймгийн ИТХ-ын 30 тойрогт 41 мандаттайгаар зохион байгуулагдсан байна.

УИХ-ын 2016 оны 4 дүгээр сарын 07-ны 32 дугаар тогтоолоор батлагдсан эх үүсвэрээс Увс аймгийн сонгуулийн хороонд Монгол Улсын Их Хурлын болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс санхүүжүүлэх зардлыг 382.3 сая төгрөгөөр баталжээ.

Засгийн газрын 2016 оны 245 дугаар тогтоолоор Засгийн газрын нөөц хөрөнгөөс санал авах байрны хамгаалалт, шатахуун, техник хэрэгслийн, цагдаагийн албан хаагчийн холбоо, хоолны зардалд Увс аймагт 9.5 сая төгрөг баталсан байна.

2016 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт УИХ-ын сонгуулийн зардалд батлагдсан төсвөөс Увс аймагт сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, цахим хуудаст байрлуулах сонгогчдыг бүртгэх, тэднийг таньж оруулах болон санал авах техник хэрэгсэл, сэлбэг, программ хангамж, тусгай тэмдэглэл хийх хэрэгсэл, тэдгээрийг худалдан авах, түрээслэх, ашиглах, хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээг хийх, хэвлэх, тээвэрлэж хүргүүлэх, татан авах болон түүнтэй холбогдсон бусад, албан хаагчийн сургалт зохион байгуулах, томилолт, мөнгөн урамшуулал, хоолны зардалд 66.8 сая төгрөгийг баталсан байна.

**1.2.** УИХ-ын болон аймгийн ИТХ-ын 2016 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах зардалд Увс аймгийн сонгуулийн хороонд улсын төсвөөс 382.3 сая төгрөгийн санхүүжилт олгожээ.

Уг эх үүсвэрийг Сонгуулийн Ерөнхий хорооний 2016 он 04 тоот тогтоолын 1-р хавсралтаар баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 2.2, 2.3 дахь заалтын дагуу аймаг, сумдын хороонд хуваарилан зарцуулжээ. Батлагдсан сонгуулийн зардлын төсвийг дараах байдалтай зарцуулсан байна. Үүнд:

| д/д | Зардлын нэр                                     | Төсөв      | Гүйцэтгэл  |                          | Үлдэгдэл  |
|-----|-------------------------------------------------|------------|------------|--------------------------|-----------|
|     |                                                 |            | Сумд       | Аймгийн сонгуулийн хороо |           |
| 1   | Саналын хуудас устгах зардал                    | 1 000 000  |            | 999 480                  | 520       |
| 2   | Тогтоол, протокол, бусад маягт хэвлүүлэх зардал | 250 000    |            | 250 000                  | -         |
| 3   | Сургалтын зардал                                | 34 146 400 | 12 752 720 | 20 451 556               | 942 124   |
| 4   | Бичиг хэргийн зардал                            | 22 200 000 | 17 796 330 | 2 251 050                | 2 152 620 |
| 5   | Шуудан холбооны зардал                          | 21 550 000 | 19 336 500 | 2 044 000                | 169 500   |
| 6   | Унааны зардал                                   | 59 440 000 | 44 964 740 | 14 373 380               | 101 880   |
| 7   | Хууль, тогтоомж сурталчлах зардал               | 8 600 000  | 3 408 200  | 5 150 000                | 41 800    |
| 8   | Санал авах байр бэлтгэх зардал                  | 17 160 000 | 16 516 380 | -                        | 643 620   |

/ төгрөгөөр/

|            |                                                                              |                    |                    |                    |                  |
|------------|------------------------------------------------------------------------------|--------------------|--------------------|--------------------|------------------|
| 9          | Саналын хуудас хүргэх зардал                                                 | 4 844 000          |                    | 4 844 000          | -                |
| 10         | ICP машиныг хүлээн авах, хүлээлгэн өгөх                                      | 14 757 200         |                    | 14 642 500         | 114 700          |
| 11         | МТБ-ийн мэдээ дамжуулах зардал                                               | 600 000            |                    | -                  | 600 000          |
| 12         | Томилолтын зардал                                                            | 8 759 600          |                    | 8 759 600          | -                |
| 13         | Эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх                                             | 4 557 000          | 4 121 000          | -                  | 436 000          |
| 14         | Сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал      | 147 494 800        | 133 799 760        | 13 783 040         | - 88 000         |
| 15         | Сонгуулийн хороонд ажилласан хугацааны мөнгөн урамшуулал, хоолны зардал \МТ\ | 31 092 800         |                    | 31 092 800         | -                |
| 16         | Болзошгүй зардал                                                             | 3 000 000          |                    | 2 053 560          | 946 440          |
| 17         | Бичиг хэргийн ажилтан, нягтлан бодогч нарын урамшуулал, хоолны зардал        | 1 700 000          |                    | 1 700 000          | -                |
| 18         | Төрөл бүрийн үнэмлэх хэвлүүлэх                                               | 1 240 000          |                    | 1 240 000          | -                |
| <b>Дүн</b> |                                                                              | <b>382 391 800</b> | <b>252 695 630</b> | <b>123 634 966</b> | <b>6 061 204</b> |

Увс аймгийн Цагдаагийн газарт санал авах байрын хамгаалалт, шатахуун, техник хэрэгслийн, цагдаагийн албан хаагчийн холбоо, хоолны зардалд хуваарилагдаж ирсэн эх үүсвэрийг батлагдсан төсвийн дагуу УИХ-ын 31, 32,33 дугаар тойрог, аймгийн ИТХ-ын сонгуулийн санал авах байрны хамгаалтанд ажилласан нийт 110 алба хаагчдын хоол, шуудан холбоо, унааны зардалд зарцуулсан байна. Увс аймгийн хэмжээнд 19 сумын 93 хэсгийн хорооны санал авах байр, аймгийн сонгуулийн хорооны хамгаалалтанд 1, нийт 94 алба хаагчдыг томилон, 16 алба хаагчдыг нөөцөөр ажиллуулсан байна. Нөөцөөр ажилласан алба хаагчид хоолны зардалд 480.0 мянган төгрөгийг зарцуулжээ. Батлагдсан зардлаас хоолны зардалд 7530.0 мянга, шуудан холбооны зардалд 940.0 мянга, шатахууны зардал 1000.0 мянга, нийт 9470.0 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Сонгуулийн тухай хуулийн 38.3-д заасан сонгууль зохион байгуулахтай холбоотой зардлын эх үүсвэр 66.8 сая төгрөгийг Улсын бүртгэл, статистикийн газрын даргын 2016 оны А/395, А/486, А/547 тоот тушаалаар захиран зарцуулах эрх өгснийг дагуу батлагдсан зардлуудыг зориулалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

| №               | Зардлын зүйл анги      | /төгрөгөөр/      |                 |
|-----------------|------------------------|------------------|-----------------|
|                 |                        | Мөнгөн дүн төсөв | гүйцэтгэл       |
| 1               | Гэрээт ажилчдын цалин  | 14430000         | 14430000        |
| 2               | Урамшуулалт цалин      | 19008000         | 19008000        |
| 3               | сургалтын зардал       | 1662000          | 1662000         |
| 4               | тээвэр шатахуун        | 9000000          | 9000000         |
| 5               | Томилолтын зардал      | 13152000         | 13152000        |
| 6               | Бичиг хэрэг            | 5516089          | 5516089         |
| 7               | шуудан холбооны зардал | 4090000          | 4090000         |
| <b>Нийт дүн</b> |                        | <b>66858089</b>  | <b>66858089</b> |

**Дүгнэлт :**

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:**

1. Увс аймгийн хэмжээнд УИХ-ын болон аймгийн ИТХ-ын сонгуульд нийт 458.6 сая төгрөгийн эх үүсвэр батлагдсныг зориулалтын дагуу зарцуулж 6.1 төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

**БҮЛЭГ. 2 Хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт үр дүнтэй хэрэгжсэн байна.**

**2.1.** Сонгуулийн Ерөнхий хорооны 2016 он 04 тоот тогтоолын 1-р хавсралтаар “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 4-д “Сонгуулийн зардлын бүртгэл хөтлөх, гүйцэтгэлийн тайлан гаргах”-тай холбоотой заалтуудыг аймаг, сумдын сонгуулийн хороо бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

**2.2.** Дээрх журмын 3 дах заалтуудын дагуу аймаг, сумдын сонгуулийн хороо Төрийн санд зардлын данс нээлгэн хуваарилсан төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу захиран зарцуулсан байна. Аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын үлдэгдэл 3.2 сая, сумдын сонгуулийн хороо сонгуулийн зардлын үлдэгдэл 2.9 сая, нийт 6.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Түүнчлэн 13 сум сонгуулийн зардлаас 10 нэр төрлийн 1711.6 мянган төгрөгийн аж ахуй, хангамжийн материал худалдан авсан ч данс бүртгэлд тусгаагүй байсныг холбогдох байгууллагуудад хандаж бүртгэлд тусгуулах зөвлөмж өглөө. /сумдын нэр, бараа материалын нэрсийг хавсралт №1харуулав/

**Дүгнэлт :**

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:**

1. 13 сум сонгуулийн зардлаас 10 нэр төрлийн 1711.6 мянган төгрөгийн аж ахуй, хангамжийн материал худалдан авсан ч данс бүртгэлд тусгаагүй байна.

**Зөвлөмж:**

**Аудитын дүнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.Үүнд:**

**Сонгуулийн хорооны дарга Г.Болор-Эрдэнэ танаа**

1. Хавсралт №1 дурдагдсан 13 сум сонгуулийн зардлаас бараа материал бэлтгэсэн ч данс бүртгэлд тусгаагүй байгааг албан тоотоор мэдэгдэх.

## Холбогдох байгууллагын санал

  
**УВС АЙМГИЙН  
СОНГУУЛИЙН ХОРОО**  
213400, Улаангом, Увс аймаг  
Утас\Факс: 7045-4708

2016.07.26 № 138  
\* танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Аймгийн Аудитын газарт

Аймгийн Сонгуулийн хорооны санхүүгийн  
дүгнэлттэй танилцлаа. Өөр нэмэлт санал байхгүй  
болно.

Дарга  Г.Болор-Эрдэнэ



**Холбогдох байгууллагын ирүүлсэн  
саналд өгөх тайлбар**

Тайлангийн төсөлтэй танилцаж Увс аймгийн Сонгуулийн хорооны 2016 оны 7-р сарын 26-ны өдрийн 138 албан тоотыг үндэслэн тайланд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзлээ.

**ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Ж.ЭНХЖАРГАЛ

АУДИТОР:

Ч.ДУЛАМСҮРЭН